



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2025.09.03 № А-1/672
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын даргын захирамжийн дагуу Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчны талаар санал, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд холбогдох мэдээллийг ирүүлэх тухай Таны 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/9628 дугаар албан бичигтэй танилцлаа.

2008 оны Дэлхийн санхүүгийн хямралын дараа санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нь санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд илүү ач холбогдолтой болсноор улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээс эхлээд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод болгох, бизнесийн ёс зүйг сахих, маргаан шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох зохицуулалтыг хийж эхэлсэн билээ.

Монголбанк Азийн хөгжлийн банктай хамтран дээрх чиглэлээр төсөл хэрэгжүүлсэн бөгөөд энэ төслийн гол бүрэлдэхүүн амжилттай хэрэгжих урьдач нөхцөл нь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах талаар Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөхөд нөлөөлж байгаа хүчин зүйлс, шинээр санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хууль тогтоомж боловсруулах хэрэгцээ, шаардлага бий эсэх, шинээр хууль боловсруулах тохиолдолд анхаарах зүйлсийг тодорхойлох зорилгоор тандан судалгааг 2022 онд хийж гүйцэтгэсэн ба уг тайланг банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээллийн хамт хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 33 хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525022662

Монголбанкны 2025 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 4-дугаар албан бичгийн Хавсралт



Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээлэл

Монголбанкны Хяналт шалгалт, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар болон Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, харилцах, хадгаламж эзэмшигч, зээлдэг болон санхүүгийн хэрэглэгч нараас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг.

Монголбанкнаас Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах замаар банкны харилцагчдын эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд харилцагч, хадгаламж эзэмшигчийн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг.

Банктай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

№	Өргөдөл	2020. III, IV	2021	2022. I, II	2023	2024. III	2025. I	2025. II
1	Иргэн	84	115	56	54	44	47	42
2	ААН	18	23	15	25	12	8	7
	Нийт	102	138	71	79	56	55	49

Банкны үйл ажиллагаатай холбоотойгоор 2024 оны эхний 3 удирлын байдлаар авч үзэхэд ирүүлсэн ирүүлсэн өргөдөл, гомдлын 21.4 хувь нь зээлийн гэрээний маргаантай холбоотой байсан бол 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 45.4 хувь нь зээлийн ангилалтай холбоотой байна.

Банктай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

№	Товч утга	2020 III, IV	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022 I, II	Эзлэх хувь	2023	Эзлэх хувь	2024 III	Эзлэх хувь	2025 I	Эзлэх хувь	2025 II	Эзлэх хувь
1	Зээлийн гэрээний маргаан	28	27.5%	41	29.7%	23	32.4%	12	15.1%	12	21.4%	8	14.51%	8	16.3%
2	Зээлийн ангилалтай холбоотой	13	12.7%	10	7.2%	4	5.6%	16	20.2%	9	16%	25	45.41%	25	51%
3	Хадгаламжийн гэрээний маргаан	7	6.9%	7	5.1%	5	7%	5	6.3%	4	7.1%	2	3.61%		
4	Ковид-19-ээс үүдсэн гэрээний маргаан	10	9.8%	26	18.8%	1	1%	3	3.7%	1	1.7%	-			
5	Дансны гүйлгээ болон битүүмж							10	12.6%	8	14.2%	3	5.41%	6	12.2%
6	Бусад	44	43.1%	54	39.1%	38	38%	33	41.7%	22	39.2%	17	30.91%	10	20.4%
	Нийт	102		138		71		79		56		55		49	

Банктай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

№	Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал	2020 III, IV	2021	2022 I, II	2023	2024 III	2025 I, II
1	Албан бичгээр хариу өгсөн	76	87	46	43	37	53
2	Утсаар хариу өгсөн	22	43	20	28	15	48
3	Улсын байцаагчийн акт, мэдэгдэл хүргүүлж шийдвэрлэсэн	1		1	1	3	2
4	Бусад байдлаар (зөрчлийн хэрэг нээж хялбаршуулсан журмаар, цахим шуудан)	3	8	4	7	1	1
Нийт		102	138	71	79	56	104

Санхүүгийн зохицуулах хороо нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар албан бичгээр 401, цахимаар 135, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 70, нийт 606 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч 555 өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан бол 51 өргөдөл, гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

Нийт өргөдөл гомдлын тоо (салбараар)

№	Салбар	2022.IV	2023.IV	2024.IV	2025.II				
					Албан бичиг	Info	11-11 төв	Нийт	Эзлэх хувь
1	Даатгал	257	453	475	162	90	43	295	49.0%
2	Үнэт цаас	135	121	137	60	4	16	80	13.0%
3	ББСБ	140	172	140	92	30	5	127	21.0%
4	ХЗХ	20	14	29	25	-	-	25	4.0%
5	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа	-	-	25	26	4	1	31	5.1%
6	ВХҮҮ	-	-	24	-	6	3	9	1.5%
7	Бусад	77	128	24	36	1	2	39	6.4%
Нийт		629	888	854	401	135	70	606	100%

Монголбанкны 2025 оны 8 дугаар сарын 3 -ны
өдрийн А.1/672-т гар албан бичгийн Хавсралт 2



**САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот 2025 он

АГУУЛГА

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	3
ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	6
ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	7
ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	10
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	11
ЗУРГАА.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	13
ДОЛОО.ЗӨВЛӨМЖ	15

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАНДАН СУДАЛГАА

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Зорилго

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөхөд нөлөөлж буй хүчин зүйлс, шинээр санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хууль тогтоомж боловсруулах хэрэгцээ, шаардлага бий эсэх, шинээр хууль боловсруулах тохиолдолд анхаарах зүйлсийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Өнөөгийн нөхцөл байдал

Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах явдал нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч талуудад зохистой харьцааг мөрдүүлэн үр дүнтэй зохицуулалт хийж, санхүүгийн боловсролыг сайжруулах алхмуудтай зэрэг хэрэгжсэнээр санхүүгийн үйлчилгээг илүү дөхөм болгох боломжийг нээдэг. Хэрэглэгчийн эрх ашгийг бодитойгоор хамгаалах нь санхүүгийн салбарын тогтвортой бөгөөд хүртээмжтэй байдалд шууд нөлөөлдөг. Түүнчлэн, хөгжиж буй орнуудад санхүүгийн салбарын хүртээмжтэй байдлыг сайжруулах гол арга замуудын нэг нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах явдал хэмээн үзэх болсон.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах бас нэгэн арга хэрэгсэл бол санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид шударга зээлийн хэм хэмжээг мөрдүүлэх явдал юм. Шударга бус, хэт түрэмгий зээллэг (predatory lending) гэдэгт ихэвчлэн зээлдүүлэгчийн зүгээс тодорхой бус нөхцөлтэй, нуугдмал зардалтай, зээлдэгчийн төлбөрийн чадвараас давсан эсвэл хэт өндөр өртөгтэй зээл олгохыг ойлгодог. Иймд, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэн зөв, тодорхой, ил тод байдлыг хангах, зээлдэгчийг төлбөрийн чадвараас нь давсан өрийн дарамтаас хамгаалах нь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын нэгэн чухал хэсэг болдог.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудлыг олон улсад анхаарч манай улсад сүүлийн жилүүдэд хэд хэдэн судалгаа хийгээд байна. Тухайлбал, Монголбанк, Азийн хөгжлийн банк хамтран “Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зарчим, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох олон улсын шилдэг туршилага” болон “Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх” талаар судалгааны ажлууд хийсэн бол Монголбанкны холбогдох газар, нэгжүүд хамтран “Банкны салбараас гадуур, өндөр хүүтэй олгогдож буй зээлийн нөхцөл байдлын түүвэр судалгаа”, “Мөнгө хүүлэлт, түүний эсрэг авах арга хэмжээ”-ний талаар судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Эдгээр судалгаануудын голлох үр дүн болон хууль, эрх зүйн орчин болон институцийн тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэвэл дараах байдалтай байна.

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалт

Монгол улсад банкны үйлчилгээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг “Иргэний хууль”, “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”, “Зар сурталчилгааны тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, “Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”, “Банкны тухай хууль” зэрэг хуулиар тус тус зохицуулж байна. Эдгээр хууль тогтоомжид хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар ерөнхий заалтууд байдаг хэдий ч санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой тусгайлсан зохицуулалт цөөн байна. Гэтэл санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо улам бүр өсөж буй энэ үед зах зээлийн онцлог байдлыг тусгасан нарийвчилсан зохицуулалт хийхгүйгээр худалдаа, үйлчилгээтэй холбоотой нийтлэг заалтаар зохицуулах нь учир дутагдалтай юм.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нэгдсэн зохицуулалтын тогтолцоо

Санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн

төлөө газар хариуцсан чиглэлийн хүрээнд гүйцэтгэж байна. Монголбанкны хувьд тогтвортой, үр ашигтай банкны тогтолцоог дэмжих, нэн ялангуяа "системийн" эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд голлон чиглэсэн хяналт шалгалтын үүргийг хэрэгжүүлж байна. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль", "Зар сурталчилгааны тухай хууль"-ийг хэрэгжилтийг хангах үүрэгтэй ажилладаг. Үүнд, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах үүрэг багтдаг хэдий ч бүх үйлдвэрлэл, зах зээлийг хамарсан хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг учир санхүүгийн хэрэглэгчтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт хийх хүний нөөцийн боломж хомс байдаг. Түүнчлэн, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, ШӨХТГ-ын хооронд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нэгдсэн зохицуулалтын тогтолцоо байхгүйгээс зарим үүрэг, хариуцлагын давхардал зэрэг шийдвэрлэх шаардлагатай асуудал их байна.

Асуудлын мөн чанар, цар хүрээ

Санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрхийг хамгаалах хэрэгцээ шаардлага, үндэслэл нь эрх мэдэл, мэдээлэл, нөөц боломжийн тэнцвэргүй байдлаас урган гардаг. Тиймээс санхүүгийн хэрэглэгч, үйлчилгээ үзүүлэгч талуудын эрх ашигтай холбоотой асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлох зорилгоор үйлчилгээ үзүүлэгч болон иргэдийн дунд хоёр төрлийн санал асуулгыг цаасан болон цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой гомдол маргааны мэдээллийг тодорхойлох зорилгоор 11 банкны дотоод аудитын тайлан болон банкны захирлуудын зөвлөл дэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүрэг бүхий бие даасан гишүүдээс мэдээлэл авсан. Тус мэдээллээс харахад сүүлийн жилд дотоод аудит болон хяналт шалгалтаар иргэн аж ахуйн нэгжтэй холбоотой 47 мянган зөрчил илэрсний 99.2 хувь нь иргэдийн, үлдсэн хэсэг нь аж ахуйн нэгжтэй холбоотой асуудал байна. Гэтэл мөн хугацаанд банкинд иргэдээс 6.5 мянган өргөдөл буюу нийт бүртгэгдсэн зөрчлийн 14 хувь нь банкинд гомдол гаргажээ. Үүнээс харахад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой асуудлаар хэрэглэгчдийн зүгээс өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй байдаг эсвэл хэрэглэгчид зөрчил гомдлын талаар мэдээлэлгүй, хэрхэн шийдвэрлүүлэх талаар ойлголтууд байдагтай холбоотой байна. Түүнчлэн, нийт өргөдөл гомдлын 0.6 хувь нь шүүхээр, 1.4 хувь нь эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлүүлсэн байгаа нь хэрэглэгчдийн хувьд шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэхэд хүндрэл ихтэй байдаг болохыг харуулж байна.

Хэрэглэгчийн судалгааг Улаанбаатар хот, 20 аймгийн 3527 иргэний дунд санамсаргүй түүврийн аргаар хийсэн. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 50 хувь нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар бүрэн мэдээллийг олж авч чаддаггүй гэсэн бол 3 хүн тутмын 1 нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой ямар нэг хүндрэлтэй тулгарч байсан гэж хариулжээ. Нийт хүндрэлийн 50 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл дутмаг, зар сурталчилгаа болон ажилтны танилцуулсан мэдээлэл бодит байдлаас зөрүүтэй байдлаас болж үүссэн гэсэн бол үлдсэн хэсэг нь дансны хуулга авах, банкны шийдвэрээр шимтгэл, хураамж авах, мэдээллийн нууцлалтай холбоотой хүндрэлүүд байна.

Энэ нь үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн мэдээллийн зөрүүтэй байдлыг харуулж буй бөгөөд мэдээллийн зөрүүг арилгах, санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн үр ашигтай, ил тод, өрсөлдөөнт орчныг бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглэгчийн эрх, санхүүгийн боловсрол гэх ойлголтууд нь нэг зоосны хоёр тал юм. Мэдээлэл хийгээд үндсэн эрхээ хамгаалуулсан хэрэглэгч нь санхүүгийн салбарт зах зээлийн сахилга батыг төлөвшүүлэх гол хүчин зүйл болоод зогсохгүй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэл муутай хэрэглэгчээс ашиг хонжоо олох бус үйлчилгээнийхээ чанар чансаагаар өөр хоорондоо шударга өрсөлдөхөд түлхэц болно.

Банкуудад бүртгэгдсэн зөрчлийн мэдээлэл хэрэглэгчийн судалгаанаас харахад гэрээтэй холбоотой асуудал багагүй хувийг эзэлж байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 70 гаруй хувь нь зөвхөн гэрээний ерөнхий мэдээлэл, үйлчилгээ үзүүлэгчийн тайлбарлаж өгсөн мэдээлэлтэй танилцдаг бөгөөд үүнд гэрээ хэтэрхий их мэдээлэл агуулдаг, танилцах хугацаа бага, мэргэжлийн үг хэллэг их байдаг учир ойлгодоггүй нь нөлөөлсөн гэжээ.

Түүнчлэн, гэрээнд үйлчилгээ үзүүлэгч талын эрх давуу байдаг, үйлчилгээ үзүүлэгч талаас гэрээ болон холбогдох материалыг нотариатаар батлуулах, даатгал хийлгэх зэрэг харилцаанд өөрийн холбоотой этгээдтэй харилцахыг сонголтгүйгээр тулгадаг, хэрэглэгчийн талаас гэрээг цуцлах, өөрчлөлт оруулах боломж хязгаарлагдмал байдаг талаар судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь

онцолжээ. Энэ нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээнд тавих стандартыг тогтоох, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага бодитоор буйг харуулж байна.

Дээр дурдсан мэдээллийн дутагдалтай байдал, үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагатай холбоотой маргаан гарах асуудал түгээмэл байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 20 хувьд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой маргаан гарч байсан гэсэн бол маргаан гаргасан иргэдийн 30 орчим хувь нь асуудлаа ямар нэг байдлаар шийдвэрлүүлж чадаагүй байна. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар санхүүгийн маргааныг шийдвэрлэдэг талаар мэдээлэлгүй байсан бол 20 орчим хувь нь тус хуулиар өөрт тохиолдсон маргааныг зохицуулахад хүндрэлтэй байсан гэж хариулжээ. Үүнээс дүгнэхэд хэрэглэгчид өөрсдийн эрх ашгийн талаар мэдээлэл хомс байдаг, маргаан шийдвэрлэх процесс удаан, цаг зав, санхүү хөрөнгө ихээр шаарддаг гэж үзэж болохоор байна.

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих стандартыг тогтоож өгөхөөс гадна санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ёс зүйн хэм хэмжээ, шударга байдалд шалгуур тогтоож, мэдээллийн тэгш бус байдал, хэрэглэгчийн золгүй явдал, эмзэг нөхцөл байдлыг ашиглан хэт түрэмгий нөхцөлтэй зээл олгох, мөнгө хүүлэхийн эсрэг арга хэмжээ авах шаардлагатай байна. Монголбанкны холбогдох газар нэгжүүдээс 2021 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн түүвэр судалгааны үр дүнгээс харахад Улаанбаатар хотын том захуудад зээлийн үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, байгууллагын зүгээс олгодог “Өдрийн зээл” нь ихэвчлэн 5-50 сая төгрөгийн хэмжээтэй, 3 сар хүртэлх хугацаатай бөгөөд хүүний түвшин сарын 6 хувь буюу бодлогын хүүнээс¹ даруй 12 дахин, банкны хүүгээс 4.6 дахин, ББСБ-ын хүүгээс 2.3 дахин өндөр тогтож байна.

Манай улсад мөнгө хүүлэлтийг тодорхойлсон нэгдсэн ойлголт байдаггүй ч дэлхий даяар мөнгө хүүлэлтийг хэн нэгэнд ямар нэгэн үндэслэлгүй, зохисгүй өндөр хүүтэйгээр мөнгө зээлдүүлэх үйл ажиллагааг мөнгө хүүлэлт гэж ойлгодог. Энгийнээр томъёолбол: “Зээлдэгч хэзээ нэгэн цагт зээлээ төлөх чадваргүй болохуйц өндөр хүү, хураамж, шимтгэл бүхий зээл олгохыг мөнгө хүүлэлт гэнэ.” Хэт түрэмгий нөхцөл бүхий зээл нь ихэвчлэн зээлдүүлэгчид ашигтай нөхцөлтэй боловч зээлдэгчийн золгүй явдал, эмзэг байдалд дөрөөлсөн, эргэн төлөх чадварт нь үл нийцсэн шинж чанартай байдаг.

Олон улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор мэдээллийн ил тод байдлыг хууль журамдаа тусгаж өгсөн байдаг. Санал болгож буй зээл нь өндөр хүүтэй болохыг зээлдэгчид урьдчилан мэдэгдэх, хяналтын хуудсыг танилцуулж баталгаажуулах зэргийг шаарддаг бөгөөд ингэснээр зээлдэгчийг зээлийн нөхцөлтэй танилцах, зөв шийдвэр гаргах боломжийг нь бүрдүүлж өгдөг.

Монгол Улсад 2022 онд барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэнийг бүтгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээл, түүний хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор **Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийг** баталж, хуулийн 17 дугаар зүйлийн 17.4.2 дахь заалтад “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох” чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх орон тооны бус **Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлд** олгохоор зохицуулсан. Тус хуулийн дагуу мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөл 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь байхаар тогтоосон байна.

¹ Тухайн хугацаанд бодлогын хүү 6% байсан.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой өмнөх хэсэгт дурдсан асуудалд дүн шинжилгээ хийж, олон улсын шилдэг туршлага, мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн хууль тогтоомж боловсруулаад хүрэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- **Санхүүгийн хэрэглэгчийг ил тод мэдээллээр хангах:** санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, нөхцөл, болзол болон агуулагдах эрсдэлүүдийн талаарх бүрэн гүйцэд, ойлгомжтой, зохистой, харьцуулж болохуйц мэдээллээр хангах, хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх,
- **Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг нэмэгдүүлэх:** үйлчилгээний чанараар өрсөлдөх орчныг бий болгох, хувийн мэдээллийн нууцлалыг чанд сахих,
- **Үйлчилгээнд тавих шаардлагыг тогтоох:** санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, төлбөр татан төвлөрүүлэхдээ шударга, албадаагүй, зохистой байдлаар харьцаж ажиллах,
- **Шударга зээлийн хэм хэмжээ, шаардлагыг тогтоох:** Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хэт түрэмгий, шударга бус нөхцөлтэй зээл олгохыг хориглох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох,

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалтад дээр дурдсан нийтлэг асуудлыг тусгахаас гадна санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих хяналт, институцийн бүтцийн асуудлыг тодорхой зааж өгөх шаардлагатай байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 59 дүгээр тогтоолын Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу санхүүгийн хэрэглэгчийн хамгаалах зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулах хувилбар

3.1.Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах

Энэ хувилбарын дагуу одоогийн хууль, эрх зүйн орчин болон институцийн тогтолцоог хэвээр үлдээх нь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нөхцөл бүрдэхгүй бөгөөд одоогийн асуудлууд хэвээр хадгалагдана. Тэг хувилбарын дагуу нэмэлт зардал, хөрөнгө гарах шаардлагагүй хэдий ч эрх зүйн зохицуулалт, институцийн тогтолцоог бэхжүүлэхгүй байх сөрөг үр дагавартай.

3.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил өрнүүлэх

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг олон нийтэд хандсан ажил өрнүүлэх замаар шийдвэрлэх боломжтой хэдий ч санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой нийтлэг шаардлага, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт шалгалтыг сурталчлан таниулах замаар хангах боломжгүй юм. Энэхүү хувилбар нь тодорхой хэмжээний зардал, хөрөнгийг шаардах хэдий ч үүсээд буй нөхцөл байдлын шалтгааныг бүрэн арилгаж, үр дагаврыг бууруулах боломжгүй тул санхүүгийн хэрэглэгчийн хамгаалахад дангаараа үр дүн өгөхгүй гэж үзэж байна.

3.3.Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулах

Энэхүү асуудалд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг олгох, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллагаас хяналт тавих зэрэг төрөөс хийх зохицуулалт шаардагдаж

байгаа хэдий ч эдгээр нь зорилгыг бүрэн биелүүлэхэд хангалтгүй юм. Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалахад дан ганц хяналт шалгалт, зөвшөөрөл олгох нь хангалтгүй тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үр дүнд хүрэхгүй гэж үзэж байна. Ийнхүү төрөөс зохицуулах нь зардал, хөрөнгийг хэмнэх боломжтой ч тулгарч байгаа бэрхшээлийг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.

3.4.Төрөөс санхүүгийн интервенц хийх

Төрөөс санхүүгийн интервенц хийх нь асуудлыг бүрэн шийдвэрлэж, түүний үүсч буй шалтгааныг арилгах үр дүнг үзүүлэхгүй юм. Асуудал нь хөрөнгө, мөнгө, санхүүгийн хүндрэл, дутагдлаас илүүтэйгээр хуулийн зохицуулалттай холбоотой бүтцийн шинжтэй асуудал тул энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх, зорьж буй үр дүнд хүрэх боломжгүй юм. Тодорхой хэмжээний зардал, хөрөнгө зарцуулна. Гэвч асуудлын шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.

3.5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх

Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэл нь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиг үүргийн хүрээнд холбогдох ажлуудаа хийсээр ирсэн хэдий ч тодорхой түвшинд шийдвэр гаргаж мөрдүүлэх хууль эрх зүйн боломжгүй тул энэхүү хувилбар нь асуудлыг шийдвэрлэж, зорилгод хүргэхгүй.

3.6.Захиргааны шийдвэр гаргах

Тулгарч буй асуудлыг "Захиргааны шийдвэр" буюу Захиргааны ерөнхий хуульд заасан нэг удаагийн эсвэл олон удаагийн тохиолдлыг зохицуулах шинжтэй захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй юм.

Төвбанк (Монголбанк)-ны тухай болон одоогийн мөрдөж байгаа хуулиар зөвхөн Монголбанкны бүрэн эрхэд хамаарагдаж байгаа харилцааг сайжруулах, банкуудад мөрдөгдөх зохицуулалтыг бий болгох боломжтой ч бусад салбар, маргаан шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэж үзэн энэ хувилбарыг зорилгод дангаараа бүрэн хүргэхгүй гэж дүгнэлээ.

3.7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулийн төслийг шинээр боловсруулснаар Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 95 хувийг эзэлдэг банкны салбар дахь нийт хэрэглэгч төдийгүй үлдсэн 5 хувийг эзэлж буй банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн зах зээл дэх бүх хэрэглэгч өөрт тохирсон аливаа санхүүгийн үйлчилгээг өөрийн итгэл үнэмшлээр авахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл, боловсролыг үнэ төлбөргүй авах, зөрчигдсөн эрхээ эрх бүхий мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлага нэмэгдэнэ гэж үзэж байна.

Асуудлыг энэ хувилбараар шийдвэрлэхэд үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс хэрэглэгчид санхүүгийн боловсрол олгох, бүтээгдэхүүн, үйлчилгээг энгийн ойлгомжтой хүргэх зэрэгтэй холбоотой нэмэлт зардал гарах хэдий ч маргаан шийдвэрлэх асуудлыг хөнгөвчилж хэрэглэгчид өөрт тохирсон үйлчилгээг оновчтой сонгодог болсноор санхүүгийн сахилга бат нэмэгдэж салбарын тогтвортой байдалд урт хугацаандаа эергээр нөлөөлнө.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж, тоймлон хүснэгт Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Хувилбарын харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Зохицуулалт хийхийг шаардаж буй асуудлуудыг шийдвэрлэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар үргэлжилнэ	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	Хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хэдий ч үйлчилгээ үзүүлэгч болон	Зардал тодорхой хэмжээнд гарах ч асуудлыг үүсгэж байгаа	

	ухуулга, сурталчилгаа хийх	маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэхгүй тул зорилгыг бүрэн биелүүлэхгүй	гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн арилгаж чадахгүй	Дангаараа үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Эрх бүхий төрийн байгууллагаас зохицуулалт хийх нь зарим талын ач холбогдолтой ч зорилгыг бүрэн хангаж чадахгүй	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй	Дангаараа үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Санхүүгийн интервенц хийх замаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг шийдвэрлэж чадахгүй	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Зохицуулалт хийхийг шаардаж буй асуудлуудыг шийдвэрлэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, одоогийн нөхцөл байдал үргэлжилнэ	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Холбогдох хуулиар зохицуулж байгаа харилцааг захиргааны шийдвэрээр “өөрөөр зохицуулах” нь зорилгод хүрэх боломжийг олгохгүй ба үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	-Асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг бий болгож, зорилгод хүрэх боломжийг бүрдүүлнэ.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Зорилгод хүрэх байдал, эерэг болон сөрөг талын зардал, үр өгөөжийг хувилбар тус бүрээр харьцуулан үзэж, “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэх ганц сонголт мөн гэж дүгнэлээ.

Хууль шинээр боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн мэргэжлийн холбогдох байгууллага (ШӨХТГ, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк), олон улсын байгууллага (Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага), үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд (мэргэжлийн холбоод) болон судалгаанд оролцсон хувь хүн, мэргэжилтнүүдийн дүгнэлтэд тулгуурлан тандан судлах ажиллагаа үргэлжлүүлэн гүйцэтгэлээ. Асуудлын шалтгаан нь одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжид санхүүгийн хэрэглэгчтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй, тус чиглэлийг хариуцсан байгууллагуудын нэгдсэн зохицуулалтын тогтолцоо байхгүй, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт сайжруулах шаардлагатай, гомдол маргааныг хянан шийдвэрлэх гэж үзсэн учир эдгээр асуудлыг нэгтгэсэн хуулийн төслийг боловсруулна.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон 1 хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа (Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралт 1-ээс үзнэ үү).

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбарын хүрээнд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалж, боловсрол олгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үүргийг тодорхойлж, бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг тогтоож өгснөөр нэг талаас хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээтэй холбоотой эрх нэмэгдэж, оновчтой шийдвэр гаргах боломж өсөх бол нөгөө талаас үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчидтэй ижил тэгш, тэнцвэртэй харьцах, санхүүгийн хэрэглэгчийн ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл бололцоо бүрдэх буюу хүний эрхэд эергээр нөлөөлнө.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Тухайн сонгосон хувилбарыг хэрэгжүүлснээр үйлчилгээ үзүүлэгчдийн өрсөлдөөн нэмэгдэж хүү, шимтгэл буурах нөхцөл бүрдэнэ. Мөн санхүүгийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой хэрэглэгчээс гарах зардал буурах бөгөөд эдгээр нь хувь хүн, гэр бүлийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлж дотоодын санхүүгийн байгууллагын хөгжилд дэмжлэг болно. Түүнчлэн санхүүгийн боловсролын түвшин нэмэгдэх нь иргэдийн санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх бөгөөд энэ нь бодлогын шийдвэр гаргалтын бодит секторт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлж, цаашлаад санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлнө. Хэрэглэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг энгийн ойлгомжтой танилцуулах, санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэхэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс тодорхой хэмжээний нэмэгдэл зардал гарах хэдий ч тус арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох эерэг үр дагавар нь эргээд үйлчилгээ үзүүлэгчийн зардлыг бууруулах нөлөөтэй гэж дүгнэж болохоор байна. Тиймээс тус хуулийн нөлөө бүхэлдээ эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд эерэг үр дагавартай гэж дүгнэж болохоор байна.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Зохицуулалтын сонгосон хувилбарын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь шинж чанарын хувьд хүний эрх, нийгэмд үзүүлж байгаа эерэг нөлөөтэй давхцаж байна. Өөрөөр хэлбэл, олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлж, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд стандарт тогтоосноор чанар нэмэгдэж, нийгмийн бүлэг ялгахгүйгээр ижил тэгш үйлчилгээ авах нөхцөл бүрдэнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хувилбарын энэхүү зохицуулалтын үед байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Байгалийн баялаг ашиглалт, нөхөн сэргээлтийн чиглэлд иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх магадлалтай.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлээр төрд эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах үүргийг хүлээлгэсэн бөгөөд энэ талаар хуульчлан баталгаажуулсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт банк, санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхдээ иргэндээ ээлтэй байх, эдийн засагтаа үр өгөөжтэй байх зарчмыг тодорхойлсон. Үүний дагуу Монголбанк нь Төрөөс баримтлах мөнгөний бодлогын 2019 оны үндсэн чиглэлд Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тогтолцоог сайжруулахаар тусгасан.

Иймд энэхүү хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчихгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулийн төслийг шинээр боловсруулах нь цорын ганц үр дүнтэй хувилбар гэж дүгнэж байна.

Хүснэгт 2. Хувилбаруудын дүгнэлт

Зохицуулалтын хувилбар:	Санхүүгийн хэрэглэгчийг ил тод мэдээллээр хангаж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг нэмэгдүүлж, үйлчилгээнд тавих шаардлагыг тогтоон гомдол маргааныг зардал багатай бөгөөд түргэн шуурхай механизмыг бүрдүүлэх хууль гаргах
Зорилгод хүрэх байдал	Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, нөхцөл, болзол болон агуулагдах эрсдэлүүдийн талаарх бүрэн гүйцэд, ойлгомжтой, зохистой, харьцуулж болохуйц мэдээллээр хангаж хэрэглэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлснээр нэг талаас хэрэглэгчдийн санхүүгийн сахилга бат сайжирч, өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг оновчтой сонгох бол нөгөө талаас энэ нь салбарын тогтвортой байдалд эергээр нөлөөлнө. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанараар өрсөлдөх орчныг бий болгон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, төлбөр татан төвлөрүүлэхдээ шударга, албадаагүй, зохистой байдлаар харьцаж ажиллах нөхцөлийг бүрдүүлснээр хүү, шимтгэлээр өрсөлдөх нөхцөл бүрдэж хэрэглэгчдийн санхүүд эерэг үр дагавартай.
Хүний эрх, эдийн засаг байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Эергээр нөлөөлнө.
Зардал үр өгөөжийн харьцаа	Хуулийг хэрэгжүүлснээр улсын төсвөөс тусгайлан зардал гарахгүй. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хэрэглэгчид санхүүгийн боловсрол олгох, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал гарах хэдий ч тус зохицуулалт хэрэгжсэнээр салбарын тогтвортой байдалд эергээр нөлөөлнө.
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Нийцэж байгаа
Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Байхгүй

Хууль батлан хэрэгжүүлснээр санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн тусгайлан зохицуулалттай болохоос эхлээд, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, бизнесийн сайн арга барилыг мөрдүүлэх, маргааныг боловсронгуй аргаар шийдвэрлэх зэргээр өнөөгийн тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжтой болно.

ЗУРГАА.САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Тухайн улс орны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь эдийн засаг, санхүүгийн салбарын бүтэц, салбарын хөгжил болон хэрэглэгчийн эрхийг хэрхэн хамгаалдаг зэргээс ихээхэн хамааралтай байдаг. Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах явдал нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч талуудад зохистой харьцааг мөрдүүлэн үр дүнтэй зохицуулалт хийж, санхүүгийн боловсролыг сайжруулах алхмуудтай зэрэг хэрэгжсэнээр санхүүгийн үйлчилгээг илүү дөхөм бөгөөд хүртээмжтэй болгож, хэрэглэгчийн эрх ашгийг бодитойгоор хамгаалах нь санхүүгийн салбарын тогтвортой байдалд мөн шууд нөлөөлнө.

Манай оронтой газар зүй, эдийн засгийн бүтэц болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоотой Турк, Армени, ОХУ, Киргизстан болон Япон улсуудын санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг сонгон судалж, голлох зүйл заалтыг олон улсын шилдэг туршлага болох Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (OECD)-ын гаргасан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн зарчмуудтай нэгтгэн Монгол улсын хувьд анхаарах зүйл, баримтлах зарчмыг тодорхойлбол дараах байдалтай байна (бусад улсын эрхзүйн зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-оос харна уу).

Хууль, зохицуулалт болон хяналт шалгалтын хамрах хүрээ:

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь хуулиар, зохицуулагч байгууллагын журам болон хяналт шалгалтын хүрээнд хамгаалагдаж, үндэсний болон дэлхийн зах зээлд суурилсан санхүүгийн салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэх ёстой. Хүчтэй, үр дүнтэй зохицуулалт, хяналт шалгалтын механизм нь хууль болон журмаар баталгаажсан байна.

Зохицуулагч байгууллагын үүрэг, оролцоо:

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулиар эрх олгогдсон зохицуулагч байгууллага нь өөрийн эрх үүргийг хэрэгжүүлэх, хариуцлага ногдуулах бүрэн эрх олгогдсон байх ёстой. Энэхүү үйл ажиллагаа нь сайн засаглалтай, бие даасан, хараат бус, ил тод байж ашиг сонирхлын зөрчлөөс ангид тогтвортой ажиллах ёстой. Олон улсын болон үндэсний түвшинд бусад зохицуулагч байгууллагатай хамтран үр дүнтэй ажиллах нь зүйтэй.

Хэрэглэгчтэй тэнцүү, шударга харилцах харилцаа:

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид нь санхүүгийн бүх хэрэглэгчидтэй тэнцүү, шударга, үнэнч харилцах ёстой. Энэ санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн сайн засаглал, байгууллагын соёлын нэг хэсэг байна. Тодорхой анхаарлыг нийгмийн эмзэг хэсэгт хандуулж ажиллах хэрэгтэй.

Ил тод байдал болон мэдээллийг нээлттэй болгох:

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчдэд өөрийн бараа, үйлчилгээний талаарх мэдээлэл, хүртэж болох ашиг, эрсдэл бусад нөхцөлийг бүрэн мэдээллээр хангах ёстой. Санхүүгийн бүх бараа, үйлчилгээний талаарх мэдээлэл үнэн зөв, ойлгомжтой, төөрөгдөлд оруулахааргүй байна. Хэрэглэгчийн мэдээлэл нээлттэй болох хууль зүйн болон гэрээний заалтыг нарийн тайлбарлах ёстой.

Санхүүгийн боловсрол ба мэдлэгтэй байх:

Зохицуулагч байгууллага, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон бусад бүх оролцогчид санхүүгийн боловсрол болон мэдлэгтэй байх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах мэдээлэл, эрх үүрэг болон хариуцлага санхүүгийн хэрэглэгчид хүндрэлгүй, амархнаар олж авахаар байна. Ирээдүйн санхүүгийн хэрэглэгчдэд чиглэсэн мэдлэг, чадвар олгож, итгэлтэй байх, ингэснээр эрсдэлээс өөрийгөө хамгаалах, санхүүгийн хувьд эрүүл, сайн байх тохирсон механизм бүхий тогтолцоог хөгжүүлэх нь зүйтэй. Улс орны хэмжээнд олон сувгаар хүүхэд насанд болон амьдралын бүх үед санхүүгийн боловсрол олгох үндэсний тогтолцоотой байх нь зүйтэй.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн бизнесийн ёс зүй:

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь ашиг сонирхлоос ангид хэрэглэгчийн ашиг сонирхлын төлөө ажиллах зорилготой байх ёстой.

Хэрэглэгчийн хөрөнгийг луйвар болон зүй бусаар ашиглахаас сэргийлэх:

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн хадгаламж, харилцах болон бусад санхүүгийн хөрөнгийг луйвар, шамшигдуулалт болон зүй бусаар ашиглахаас хамгаалах арга хэрэгсэл, хяналт, хамгаалалттай байна.

Хэрэглэгчийн хувийн нууц, мэдээллийг хамгаалах:

Хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээллийн хууль зүйн болон журмын хүрээнд хамгаалсан тогтолцоо, журамтай байна. Энэ журмаар ямар мэдээлэл авагдах, хэрэглэгдэх, хадгалагдах, нээлттэй болгох буюу гаргаж өгөх асуудал зохицуулагдсан байна.

Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах:

Санхүүгийн харилцагчийн гомдлыг шийдвэрлэх тогтолцоо зохицуулагч болоод санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн дотоод бүтцэд байх ёстой. Энэхүү тогтолцоо нь хэрэглэгч бүрт хялбар, илүү зардалгүй, энгийн, чирэгдэлгүй, бие даасан, хараат бус, шударга, ил тод, цаг хугацааны хувьд хэмнэлттэй, хүнд сурталгүй байж гомдлыг барагдуулах ёстой.

Өрсөлдөөн: Үндэсний болон олон улсын өрсөлдөөнт зах зээлийг хөгжүүлж санхүүгийн хэрэглэгчдэд илүү сонголт бүхий санхүүгийн бараа, үйлчилгээг өндөр чанараар хүргэх нь зүйтэй. Санхүүгийн хэрэглэгчид санхүүгийн бараа, үйлчилгээг хайх, харьцуулах, сонгох, солих боломжтой байх хэрэгтэй.

Тав¹. Зээлийн хүүний дээд хязгаар тогтоох олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Дэлхий даяар 76 улс оронд зээлийн хүүний ямар нэгэн хязгаарлалтыг хэрэгжүүлдэг ба эдгээр хязгаарлалтын төрөл, хамрах хүрээ өөр хоорондоо ихээхэн ялгаатай байдаг. Зээлийн хүүний хязгаарлалт зөвхөн зах зээлийн нэг сегментэд үйлчлэх эсхүл макро эдийн засгийг бүхэлд нь хамарсан байж болно.

Олон улсын судалгааны тайлангуудаас үзэхэд **Франц, Герман, АНУ** зэрэг нэлээд олон улсад зээлийн хүүний ямар нэгэн дээд хязгаарыг тогтоож өгсөн ба эдгээр хязгаарлалтууд мөнгө хүүлэгчид (loan sharks) болон хэт түрэмгий зээлдүүлэгчдийг чиглэсэн байх нь элбэг. Ялангуяа санхүүгийн хямралын дараа өдрийн зээл (payday loans) зэрэг өндөр хүүтэй, богино хугацаатай зээлийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, энэ төрлийн үйлчилгээг үзүүлдэг зээлдэгчид хурдтай олширсон байдаг байна. (Бусад улсын мөнгө хүүлэлтийн эсрэг эрхзүйн зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 3-аас харна уу).

Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох замаар мөнгө хүүлэлттэй тэмцдэг зарим улс орнуудын туршлагаас үзвэл эдгээр улсуудад зээлийн өртгийн дээд хязгаарыг хуулиар тогтоосон байдаг бөгөөд дийлэнх нь мөнгө хүүлэлтийн эсрэг тусгайлсан хуультай байна. Эрх зүйн зохицуулалтыг дараах хуулиудад тусгасан байдаг. Үүнд:

1. Мөнгө хүүлэлтийн эсрэг хууль: Чили, Колумб, Франц, Итали, Япон, Киргиз, Намиби, Никарагуа, Уругвай (9);
2. Эрүүгийн эсвэл иргэний хууль: Армени, Канад, Египет, Эстони, Мальта, Польш, Тайланд (7);
3. Тушаал: Боливи, Португал, Тунис (3);
4. Банкны тухай хууль: Энэтхэг, Турк, Замби (3);
5. Хэрэглээний зээлийн тухай хууль: Австрали, Словак, Өмнөд Африк, Испани (4);
6. Бичил санхүүгийн тухай хууль: Бангладеш, Мьянмар (2);
7. ХЗХ-ны тухай хууль: Ирланд, Их Британи (2).

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Энэхүү тандан судалгааны зорилгын дагуу асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулах хувилбаруудын үр нөлөө, эерэг сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулийг шинээр боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж дүгнэлээ.

Монгол улстай газар зүйн хувьд ойролцоо, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоотой Турк, Армени, ОХУ, Киргизстан болон Япон зэрэг орны хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа, олон улсын байгууллагуудын зөвлөмж дээр үндэслэн хуулийн төслийг боловсруулж, доорх үр дүнд хүрнэ:

- Санхүүгийн хэрэглэгч үйлчилгээг чөлөөтэй сонгож, үйлчилгээний талаар ойлгомжтой бүрэн гүйцэд мэдээллийг үнэ төлбөргүй авна,
- Шударга зээлийн хэм хэмжээг тогтоож, зээлдэгчийг төөрөгдүүлсэн, тодорхой бус, нуугдмал шинжтэй нөхцөл бүхий зээлийн гэрээний харилцаанаас хамгаална,
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага бүр хэрэглэгчид үйлчлэх стандартыг боловсруулж, хэрэглэгчийн ашиг сонирхлын төлөө ажиллана,
- Үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага нэмэгдэж, тэдний үүрэг хариуцлага өндөрсөнө.

Дээрхээс гадна санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах бие даасан хуультай болсноор санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, институцын бүтэц тодорхой болж, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн хоорондын итгэлцэл сайжрах бөгөөд улмаар үйлчилгээ үзүүлэгчид үйлчилгээний үнэ, шимтгэл хүүгээр өрсөлдөх хандлага давамгайлж, хэрэглэгчдийн санхүүгийн мэдлэг, санхүүгийн сахилга бат нэмэгдэж урт хугацаандаа эдгээр нь санхүүгийн салбарын тогтвортой байдалд эергээр нөлөөлнө.

Харин, зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох олон улсын туршлага, үндэслэл, үр дагаврыг судалсны үндсэн дээр мөнгө хүүлэлтийн эсрэг дараах зохицуулалтыг мөнгө хүүлэлтийн эсрэг тусгайлсан хуульд тусгахаар дэвшүүлж байна. Үүнд:

- “Жишиг хүү”-г банкуудын зээлийн тайлан дахь шинээр олгосон төгрөгийн зээлийн сүүлийн 3 сарын жилийн дундаж хүүг сард шилжүүлсэн түвшнээр тогтоох;
- “Мөнгө хүүлэх хүү”-г зээлийн жилийн бодит өртөг (APR)-аар тодорхойлох бөгөөд жишиг хүүний түвшнээс 4 дахин^[1] болон түүнээс өндөр хүүний түвшнээр тодорхойлно. Энэхүү томъёоллын дагуу тооцож үзэхэд мөнгө хүүлэх хүү нь 2021 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар сарын **4.52**^[2] хувьтай тэнцэж байна.
- “Мөнгө хүүлэлт”-д зээлдэгчийн хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтой буюу зээлийн нийт хугацаан дахь хүү, шимтгэл, хураамж, тэдгээртэй адилтгах нэмэлт төлбөрийн нийлбэр нь мөнгө хүүлэх хүүгээр олгосон зээлийн хүүний орлогоос их байх тохиолдлыг хамруулах.

ХАВСРАЛТ 1. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ

Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн баримтлах зарчимд ижил тэгш, шудрага харилцах талаар тусгана
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Хөндсөн зохицуулалт тусгагдаагүй
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Өрсөлдөөнийг шударга, хэрэглэгчдэд ээлтэй байх зарчимд тулгуурлан сөрөг үр дагаврыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Хөндсөн зохицуулалт тусгагдаагүй
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Хөндсөн зохицуулалт тусгагдаагүй
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Харшлах зохицуулалт байхгүй
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Харшлах зохицуулалт байхгүй
1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулна.	
Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хөндсөн зохицуулалт байхгүй
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Хөндсөн зохицуулалт байхгүй

Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хэрэглэгч • Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч • Санхүүгийн хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх эрх бүхий байгууллага
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хөндсөн зохицуулалт байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		Хөндсөн зохицуулалт байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/		Үгүй	Хөндсөн зохицуулалт байхгүй
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулагч байгууллагаас тусгай зөвшөөрөл олгоно
Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Хүйсээр ялгаварлах асуудалгүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Санхүүгийн хэрэглэгчийг хүйсээр хязгаарлах зохицуулалт байхгүй

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх			
Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Хэрэглэгч бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар ил тод, бодит мэдээлэлтэй болсноор шийдвэр гаргах боломж нэмэгдэнэ
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Бодит мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах нөхцөл бүрдсэнээр үйлчилгээний чанараар өрсөлдөх нөхцөл бий болно
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Хэрэглэгчдийн мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалан үйлчилгээ үзүүлэгчид үүсдэг байсан зардлыг хэмнэнэ
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм		Хэрэглэгчид санхүүгийн боловсрол олгох, энгийн ойлгомжтой мэдээллээр хангахтай холбоотой зардал гарна
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй

	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хэрэглэгч бодит мэдээлэлд үндэслэн харьцуулалт хийх боломж бүрдсэнээр эерэг нөлөө үзүүлнэ
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн талаар илүү бодит мэдээлэлтэй болно
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Хэрэглэгчдийн эрх ашигт бүх талаар эерэг нөлөөлнө
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хэрэглэгч бодит мэдээлэлд үндэслэн харьцуулалт хийх боломж бүрдсэнээр эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.

	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Зөрчилдөөн үүсэхгүй.

Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйлчилгээний чанар нэмэгдэнэ
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн баримтлах зарчмыг тодорхойлно
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Нийт хэрэглэгчид ижил тэгш үйлчлэх нөхцөл бүрдэнэ
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг нэмэгдэнэ.

	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Соёлын өвийг хөндсөн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөлөлгүй
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Нөлөөлөлгүй

**ХАВСРАЛТ 2. УЛСУУДЫН САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ
ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

Д.д	Хуулийн бүтэц	Армени улс
1	Хуулийн зорилт	<p>Банкны харилцах, хадгаламж татах тухай хууль Энэ хуулиар банкнууд иргэдээс харилцах, хадгаламж татахад ашиглах мэдээллийн агуулга, тус мэдээллийг тараах журам, нөхцөл, харилцах, хадгаламжийн гэрээг сурталчлах болон харилцах, хадгаламжийн хүүгийн тооцоолол болон харилцах, хадгаламж эзэмшигчдийн хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах хуулийн харилцааг зохицуулна.</p> <p>Хэрэглээний зээлийн тухай хууль Энэхүү хуулиар зээлийн гэрээний талуудын харилцаа, тэдгээрийн төрөл, онцлог болон зайлшгүй шаардлагатай нөхцөлүүд, жилийн бодит хүүгийн тооцоолох аргачлал, зээлийн өр төлбөр, зээлийн гэрээний дагуух харилцагчийн эрх болон зээлийн гэрээтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.</p>
2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	<p>Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага:</p> <ul style="list-style-type: none"> (i) Бүгд Найрамдах Армен Улсын төв банк; (ii) Шүүх; (iii) Арбитр; (iv) Санхүүгийн системийн зуучлагч;
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	<p>Санхүүгийн байгууллага өөрийн санал болгож буй бүтээгдэхүүний гэрээ бүрийн шимтгэл, хүү, жилийн бодит өгөөж, зөрчил гаргасан тохиолдолд оногдуулах торгууль болон журам, нөхцөлийг багтаасан мэдээллийн товхимлыг баталж, нийтэд танилцуулах үүрэгтэй. Бүх төрлийн гэрээг хамарсан мэдээллийг нэгдсэн нэг товхимолд нийлүүлж болох бөгөөд энэ тохиолдолд уг товхимол нь хадгаламжийн гэрээний төрөл бүрийн талаар тус тусын мэдээллийг агуулсан байх ёстой байна.</p>
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	<ol style="list-style-type: none"> 1. Харилцагчийн банкны үйлчилгээ авах эрх зөрчигдсөн тохиолдол нотлогдвол банк нь 30 хоногийн дотор хадгаламж эзэмшигчид гурван зуун мянган драмыг төлнө. / =781.19 \$/ 2. 1 дэх заалт нь хадгаламж эзэмшигчийн учирсан хохирлоо барагдуулах нөхөн төлбөр шаардах эрхийг хязгаарласан болон үгүйсгэсэн болохгүй. 3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгын хүрээнд Төв банк нь өөрийн эрх зүйн актуудаараа дамжуулан мэдээллийг хангах талаар шаардлагыг тодорхойлох ба хэрэглэгчийн эрх зөрчигдсөн гэж тогтоовол эх сурвалжийг олон нийтэд дурдаж болно.
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	<ol style="list-style-type: none"> 1. Төв банк хуулийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй 2. Энэ хууль болон бусад эрх зүйн актад тусгагдсан харилцагчийн эрхийг шүүхээр хамгаалах ба хуульд заасан тохиолдолд арбитр болон санхүүгийн системийн зуучлагч мөн хамгаална. 3. Зээлдүүлэгч нь энэ хуулиар тодорхойлсон хэрэглэгчийн эрхийг зөрчсөн тохиолдолд харилцагч нь шууд шүүх эсвэл Санхүүгийн системийн зуучлагчид хандах, өөр бусад хуульд заасан тохиолдолд худалдааны арбитрт хандах эрхтэй. Зээлдүүлэгчийн зүгээс үйлчилгээ авах харилцагчийн эрх зөрчигдсөн нь нотлогдсон тохиолдолд шүүхийн шийдвэр эсвэл Санхүүгийн системийн зуучлагчийн шийдвэрээр гурван зуун мянган драмыг /781 \$/ харилцагчид олгоно.

6	Хуулийн онцлог заалт, хэсэг	Энэхүү хуульд санхүүгийн байгууллагаас голлон санал болгох бүтээгдэхүүн бүрд нь тусгайлсан заалтууд багтаж байна. /хадгаламж, зээл, кредит карт, онцгой заалт бүхий зээлийн гэрээ/
---	-----------------------------	--

(Үргэлжлэл)

Д.д	Хуулийн бүтэц	Киргизстан улс
1	Хуулийн зорилт /журам/	<p>Үйлчлүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, санхүүгийн үйлчилгээг үзүүлэх болон энэхүү үйлчилгээг үзүүлэх үеийн үйлчлүүлэгчдийн хүсэлтийг хянан шийдвэрлэхэд Үндэсний төв банкаар зохицуулагддаг бусад зээл-санхүүгийн байгууллага (цаашид ЗСБ), зээлийн хоршоо, бичил санхүүгийн байгууллага, банкны үйл ажиллагаанд тавигдах энгийн шаардлагыг тогтоох, мөн түүнчлэн үйлчлүүлэгчдийн эрхийг хамгаалахын хүрээнд Үндэсний төв банк болон ЗСБ-ын хооронд харилцан ажиллах журам болон чадавхыг тодорхойлоход оршино.</p>
2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	<p>Үндэсний банкны бүрэн эрхт салбар нэгж нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилгын хүрээнд дараах эрхүүдийг эдэлнэ:</p> <p>1/ ЗСБ-аас шаардлагатай мэдээллийг цаасан хэлбэрээр авах;</p> <p>2/ Үйлчлүүлэгчдээс ирсэн санал хүсэлтийн дагуу тодруулах асуулт гарвал ЗСБ-ын төлөөлөгчтэй уулзах;</p> <p>3/ Үйлчлүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар нэгдсэн үзлэг шалгалтад ЗСБ-тай хамтрах;</p> <p>4/ Үйлчлүүлэгчидтэй хамтрах хамтын ажиллагааг сайжруулах санал зөвлөгөөнүүдийг, мөн түүнчлэн хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээх болон зөрчлийг арилгах шаардлагуудыг ЗСБ-руу явуулах;</p> <p>5/ ЗСБ ба тэдний төлөөлөгчдөд нь авагдаж буй арга хэмжээний талаар Үндэсний банкны шалгалтын хороонд мэдэгдэх;</p> <p>6/ Үндэсний банкны бүрэн эрхт салбар нэгж нь санхүүгийн үйлчилгээний чанар болон журмыг мөрдлөгө болгож байгаа эсэхийг шалгах зорилгоор "нууц үйлчлүүлэгч" арга хэмжээг гуравдагч этгээдийн оролцоотой зохион байгуулах эрхтэй.</p> <p>"Нууц үйлчлүүлэгч" арга хэмжээ нь ЗСБ-ын оффист ажлын цагаар, Үндэсний банкны бүрэн эрхт салбар нэгжид иргэнээс хүсэлт ирээгүй тохиолдолд календарийн жилийн турш нэг газарт нэгээс дээшгүй удаа зохион байгуулагдана. "Нууц үйлчлүүлэгч" арга хэмжээний үр дүнг бүртэл хуудсанд (энэхүү журмын хавсралт 3-т зааснаар) бөглөж ЗСБ-ын удирдлагад мэдээнэ.</p> <p>Үйлчлүүлэгчдийн хүсэлтийг авч үзэх болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд ЗСБ нь дараах үндсэн зарчмуудыг мөрдлөгө болгоно. Үүнд:</p> <p>1) хуулийн дагуу байдал, үнэн зөв, нягт нямбай, ил тод, ухаалаг, шударга байдал, нийгмийн хариуцлагатай байдал;</p> <p>2) үйлчлүүлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах болон хүндэтгэх, тэдэнтэй хамтран ажиллах;</p> <p>3) хүсэлтийг зайлшгүй авч үзэх, гарсан үр дүнг танилцуулах;</p> <p>4) хүсэлтийг цаг тухайд нь, үнэн зөв, бүрэн дүүрэн авч үзэх;</p> <p>5) үйлчлүүлэгчдийн хүсэлтийг авч үзэхдээ тэгш хандах;</p> <p>6) Банкны нууцыг бүрдүүлж буй мэдээллийн аюулгүй байдлыг хангах, задруулахгүй байх.</p>

		7) Үйлчлүүлэгчдийн хүсэлтийг үнэ төлбөргүй авч үзнэ. ЗСБ нь ямарваа нэгэн хэлбэрээр үйлчлүүлэгчдийг тэдэнтэй харилцахыг хязгаарлах эрхгүй. Хүсэлтийг хүлээн авахаас татгалзахыг зөвшөөрөхгүй.
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	-
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	<p>ЗСБ нь санал хүсэлт хүлээн авах дэс дараалалтай байна. Санал хүсэлт хүлээн авах дэс дараалал нь энэхүү журам, хууль тогтоомж, Үндэсний банкны эрх зүйн актад нийцсэн байх, мөн бусад хэм хэмжээ нь дээрх журам, хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байх ёстой. Хүсэлт гаргах заавар, хүсэлтийг ЗСБ-д авч үзэх дэс дарааллын талаарх мэдээлэл, мөн түүнчлэн санал гомдлын ном нь үйлчлүүлэгчдийн нүдэнд харагдахуйц нээлттэй газарт (мэдээллийн самбар г.м) байрласан байх ёстой. Мөн санал хүсэлт хүлээн авах дэс дарааллын цахим хэлбэр нь (үйлчлүүлэгчдэд хамааралтай хэсэгт) ЗСБ-ын албан ёсны цахим хуудсанд (хэрэв байгаа бол), ЗСБ-ын албан ёсны цахим хуудасны үндсэн цэсэд холбоос нь байрших ёстой. ЗСБ нь үйлчлүүлэгчдийн шаардлагын дагуу санал хүсэлт авч үзэх журмыг тайлбарлан таниулах үүрэгтэй.</p> <p>Санал гомдлын ном нь ЗСБ-ын ажлын байр бүрд байх ёстой (төв, салбар, хадгаламжийн касс г.м). Санал гомдлын ном нь дугаарлагдсан, үдэгдсэн, ЗСБ-ын гарын үсэгтэй, тамгалагдсан байх ёстой. ЗСБ-ын хариуцсан ажилтан нь өдөр бүр өдрийн төгсгөлд санал гомдлын дэвтрийн мэдээллийг (хэрвээ гомдол ирсэн тохиолдолд) цуглуулж, дараагийн өдөр нь журамд заагдсаны дагуу шийдвэрлүүлэхээр удирдлагад шилжүүлнэ. ЗСБ-ын бусад офиссын ажилтнууд (салбар болон төвөөс бусад) өдөр бүр өдрийн төгсгөлд санал гомдлын номын мэдээллийг цуглуулж журамд заагдсаны дагуу бүргэж шийдвэрлүүлэхээр ЗСБ-ын хариуцсан ажилтанд шилжүүлнэ.</p>
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	ЗСБ-ын ажилтнууд болон удирдлагууд нь Үндэсний банкны бүрэн эрхт салбар нэгжтэй үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг авч үзэхэд туслах, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх болон хамтарч ажиллах үүрэгтэй. Мэдээллийг ирүүлэхээс татгалзсан, мэдээллийн үнэн зөв бүрэн байдлыг хангаагүй эсвэл энэхүү журмын шаардлагыг зөрчсөн ЗСБ болон бусад албан тушаалтанд Бүгд Найрамдах Киргиз улсын хууль, Үндэсний банкны дүрэм журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

(Үргэлжлэл)

Д.д	Хуулийн бүтэц	Турк улс
1	Хуулийн зорилт	<p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль</p> <p>Энэ хуулийн зорилт нь хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг авах, хэрэглэгчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байгаль орчны аюулаас хамгаалах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, боловсрол олгох, хэрэглэгчийн өөрийгөө хамгаалах санаачилгыг дэмжих, мөн энэ чиглэлээр бодлого боловсруулахад чиглэсэн сайн дурын байгууллагуудыг дэмжихтэй холбоотой асуудлыг зохицуулахад оршино.</p>

2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага: (i) Гааль, худалдааны яам; (ii) Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хяналтын газар; (iii) Хэрэглэгчийн асуудлаарх Арбитрын хороо;
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Үндэсний Боловсролын яам нь хэрэглэгчийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор боловсролын байгууллагуудын хөтөлбөрт шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. • Үндэсний радио, телевизүүд нь хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд сар бүр 15 минутаас дээш урттай хөтөлбөрийг 08:00-22:00 цагийн хооронд дамжуулах үүрэгтэй. • Үндэсний радио, телевизүүд сар бүр, нэвтрүүлгийн огноо, цаг, үргэлжлэх хугацаа, агуулга зэргийг багтаасан жагсаалт бүхий мэдээллийг Радио, телевизийн дээд зөвлөлд тогтмол хүргүүлэх үүрэгтэй. Энэ хуульд заасан хугацаанаас гадуур хийсэн нэвтрүүлгийг тус 15 минутын нэвтрүүлэгт тооцохгүй.
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	Яам нь мужийн төвүүдэд Хэрэглэгчдийн асуудлаарх хамгийн багадаа нэг арбитрын хороо байгуулж, зохих төв хотуудад үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Хэрэглэгчдийн гомдол, маргааныг шийдэх шийдлийг олохын тулд хэрэглэгчийн шаардлагыг зохицуулалтаар тодорхойлогддог.
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	Хэрэглэгчдийн асуудлыг төрөөс байгуулагдсан Арбитрын хороо хариуцаж ажилладаг байна. Тус хороо нь аймаг тус бүрд байдаг бөгөөд 5 гишүүнтэй. Тус хороо нь холбогдох байгууллагуудаас бүх төрлийн мэдээлэл, баримт бичгийг шаардаж болно. Шийдвэр Хэрэглэгчийн асуудлаарх Арбитрын хорооны шийдвэрийг талууд заавал биелүүлэх үүрэгтэй.
6	Хуулийн онцлог заалт, хэсэг	Хуульд санхүүгийн бүтээгдэхүүн тус бүрээр зүйл ангиуд /хэрэглээний зээл, зээлийн хүү, даатгал, дэфаулт, хүүгийн орон сууцны зээл, хүүгийн түвшин, бөгөөд мөн хэрэглэгчдийг санхүүгийн луйвраас хамгаалсан зүйл анги багтана. Мөн тус хуульд зөрчил гарсан нь тогтоогдсон тохиолдолд ноогдох мөнгөн торгуулийн дүн орсон байна.

(Үргэлжлэл)

Д.д	Хуулийн бүтэц	Серб улс
1	Хуулийн зорилт	Энэ хуулиар банк, санхүүгийн лизингийн үйлчилгээ үзүүлэгч болон нийлүүлэгчийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрх, тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах нөхцөлийг зохицуулна.
2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	Сербийн Үндэсний банк санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хянах ба даатгалын компани, сайн дурын тэтгэврийн сангийн менежментийн компаниудыг Санхүүгийн зохицуулах агентлага хянана.

		<p>Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал эрхэлсэн яам нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль тогтоомжийн дагуу санхүүгийн зохицуулалтын үйлчилгээ үзүүлэгчид хяналт тавина.</p> <p>Сербийн Үндэсний банк нь хэрэглэгчийн гомдол, санал, хуулийн дагуу хамгаалалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бэхжүүлж байна.</p>
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	<ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүний зар сурталчиллагааны ёс зүй • Санхүүгийн үйлчиллэгээ үзүүлэгч нь хэрэгжүлдэд зөвлөгөө өгөх зохих мэдлэг, мэргэшилтэй байх ёстой. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид нь үйлчилгээ үзүүлэгчиддээ мэргэшсэн байх сургалтыг зохион байгуулсан байх ёстой. • Хэрэглэгчид бүтээгдэхүүн санал болгохоос өмнөх мэдээлэл өгөх • Гэрээ байгуулагдахаас өмнөх зөвлөх үйлчилгээг явуулах зарчмыг хэрэгжүүлдэг.
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	<p>Санхүүгийн хэрэглэгчид нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хууль зүйн заалтууд, бизнесийн ерөнхий нөхцөлүүд, бизнесийн сайн туршлага, үүрэг хариуцлагыг биелүүлээгүй гэж үзвэл эдгээр үйлчилгээг үзүүлэгчид бичгээр гомдол гаргах эрхтэй.</p> <p>Хэрэв энэ санхүүгийн хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэгчийн хариу сэтгэл хангалуун бус байвал мөн үйлчилгээ үзүүлэгч нь 30 хоногийн дотор хариу ирүүлээгүй тохиолдолд хэрэглэгч нь хүсэлтээ Сербийн Үндэсний банкинд мэдэгдэж болно.</p> <p>Сербийн Үндэсний банк нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн гомдол гаргах, шийдвэрлэх журамыг батлан мөрдүүлнэ. Санхүүгийн хэрэглэгчээс ирсэн гомдлын дагуу Сербийн банк нь тухайн гомдолд хариу ирүүлэх, шийдвэрлэх талаар санхүүгийн үйлчиллэгээ үзүүлэгчээс ажлын 8 хоногийн дотор нэхэмжилнэ. Хэрвээ хариуг хугацаанд нь өгөөгүй тохиолдолд маргааныг шийдвэрлэх акт тогтооно.</p>
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	<p>Хэрэглэгчийн болон санхүүгийн үйлчилгээгээ үзүүлэгчийн гэрээний хооронд байгуулсан гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэхээр- ЗУУЧЛАГЧ тогтолцоогоор шийдвэрлэж болно.</p> <p>Зуучлах үйл явцыг санал хүлээн авах замаар үүсгэн байгуулна. Зуучлах журам нь нууц, яаралтай байх ёстой.</p> <p>Зуучлалын ажиллагааг Сербийн Үндэсний Банкны ажилтнууд гүйцэтгэнэ. Сербийн Бүгд Найрамдах Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр, зуучлагчаар томилогдсон эрх бүхий байгууллагын шийдвэрээр зуучлагч томилогдсон зуучлагчид болон зуучлагчаар томилогддог.</p> <p>Зуучлагчдын жагсаалт:</p> <p>Маргалдагч талууд өөрөөсөө өмнө зуучлан явуулах шийдвэр гаргаж болно.</p> <p>Зуучлах үүрэг бүхий байгууллага.</p> <p>Сербийн Үндэсний Банкны өмнө зуучлалын үйл явц нь чөлөөтэй байх болно.</p>
6	Хуулийн онцлог заалт, хэсэг	<p>Санхүүгийн бүтээгдэхүүн тус бүрээр гэрээнд заагдах зарчмыг оруулсан мөн хүү, ханш, гэрээг урьдчилан цуцлах зэрэг онцлог байгаагаас гадна торгуулийн дүнг тодорхой оруулсан байна.</p>

Мөн зээлийн хүүнд хязгаарлалт тавьсан бөгөөд санхүүгийн үйлчилгээний цахим ажиллагаа болон хэрэглэгчийн мэдээллийн ил тод байдлыг хангах заалт нэмэгдсэн.

Д.д	Хуулийн бүтэц	БНСУ улс
1	Хуулийн зорилт	<p>Санхүүгийн бүтээгдэхүүн борлуулагч, санхүүгийн бүтээгдэхүүний зөвлөхүүд бизнесээ явуулахдаа дагаж мөрдөх үүрэг, санхүүгийн хэрэглэгчдийн талаар баримтлах бодлого, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг, тэдгээрийн сонирхлыг дэмжих, санхүүгийн бүтээгдэхүүн зуучлах бизнес болон санхүүгийн бүтээгдэхүүний зөвлөгөө өгөх бизнест зах зээлийн зохистой дадал бий болгох зорилгоор санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад оршдог байна.</p>
2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	<p>(i) Санхүүгийн үйлчилгээний хороо Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, бодлого тогтоох, санхүүгийн боловсролын хөтөлбөр боловсруулах, санхүүгийн чадавхийн судалгааг 3 жил тутамд 1 удаа хийж гүйцэтгэдэг.</p> <p>(ii) Санхүүгийн боловсролын зөвлөл Санхүүгийн чадавхийн судалгаанд суурилсан бодлогыг цогцоор боловсруулж хэрэгжүүлдэг. 25 гишүүнтэй Санхүүгийн үйлчилгээний дэд дарга удирддаг.</p> <p>(iii) Санхүүгийн хяналт, шалгалтын алба Эвлэрүүлэн зуучлах хороог удирдах, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хэрэгжүүлэх байгууллага</p> <p>(iv) Эвлэрүүлэн зуучлах хороо</p>
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	Санхүүгийн чадавхийн судалгааг 3 жил тутамд 1 удаа хийж гүйцэтгэдэг ба тус судалгааны үр дүнд суурилсан цогц бодлого боловсруулж, боловсролын системд суулгадаг.
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	Өргөдөл, гомдлыг Санхүүгийн үйлчилгээний хороо нь хүлээн авч Эвлэрүүлэн зуучлах хороонд хүргүүлдэг. Эвлэрүүлэн зуучлах хороо гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шалгаж, хэлэлцдэг бол 60 хоногийн дотор эвлэрэх тухай мэдэгдэл гаргадаг байна. 2 тал эвлэрэх тухай мэдэгдлийг зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхээр шийддэг байна. боловч бага дүнтэй /20 сая воноос доош/ өргөдөл, гомдол нэгэнт эвлэрүүлэн зуучлах хороонд очсон бол түүний шийдвэр эцсийх байдаг.
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	Бага дүнтэй /20 сая воноос доош/ өргөдөл, гомдол нэгэнт эвлэрүүлэн зуучлах хороонд очсон бол түүний шийдвэр эцсийх байдаг.
6	Хуулийн онцлог заалт, хэсэг	Санхүүгийн хэрэглэгчийг мэргэжлийн болон ердийн санхүүгийн хэрэглэгч гэж 2 ангилдаг байна.

(Үргэлжлэл)

Д.д	Хуулийн бүтэц	Оросын холбооны улс
1	Хуулийн зорилт /журам/	Бараа, ажил, үйлчилгээ авахад хэрэглэгч болон бэлтгэн нийлүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, импортлогч, худалдагч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулахад орших бөгөөд, хэрэглэгчийн өөрийн амь нас, эрүүл мэнд, хэрэглэгчийн өмч хөрөнгө, байгальд ээлтэй, тодорхой чанарт нийцсэн бараа, ажил, үйлчилгээ авах эрхийг тогтоох болон бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг тогтоох, соён гэгээрүүлэх, улсын болон нийтийн эрх ашгийг хамгаалах бүтцийг тодорхойлоход оршино.
2	Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах төрийн эрх бүхий байгууллага, тэдний эрх үүрэг	ОХУ-ын засгийн газрын бүтцэд хамаарах Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах холбооны байгууллага дараах эрх, үүрэгтэй байна: 1/ Олон улсын гэрээ, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу бэлтгэн нийлүүлэгч нар т хяналт, шалгалт хийх; 2/ Олон улсын гэрээ, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу бараа, ажил, үйлчилгээ нь эрүүл мэнд, амь нам, хүрээлэн буй орчин болон ташаа, хэт төөрөгдүүлэх байдлаас хамгаалах; 3/ОХУ-ын хууль, эрх зүйд заасан зөрчлийг гаргасан бол зөрчлийг тогтоох, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоох, зөрчлийг арилгуулах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох; 4/Бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгч этгээдэд стандарт, шаардлагын дагуу байнгын хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 5/Бэлтгэн нийлүүлэгчийн зүгээс хэрэглэгчийг ташаа, төөрөгдүүлсэн мэдээллээр хангасан, гэрээ, стандарт, хууль, тогтоомжийг зөрчин цаг хугацаандаа, бүрэн буй байдлаар бараа, ажил, үйлчилгээ үзүүлсэн зэрэг статистик мэдээллийг хөтлөх; 6/Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах улсын бодлого үр дүнтэй байгаа эсэхэд дүгнэлт, шинжилгээ хийх, энэ талаар засгийн газрын өмнө тайлагнах; 7/ Бусад хууль, тогтоомжийн дагуу Хяналтын худалдан авалт хийх (прокурорын байгууллагын хяналтан дор, хяналтын худалдан авалт хийсэнтэй холбогдуулан байшин, оффис, үйлдвэрт нэвтрэх, бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой бичиг баримт, мэдээллийг авах); 8/ Шүүх үйл ажиллагаанд оролцуулах, шаардлагатай гэж шүүхээс үзвэл өөрийн болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор мэдүүлэг болон шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор оролцох.
3	Санхүүгийн боловсрол ба мэдлэг	Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах хуулийн дагуу холбооны байгууллага нь дараах үүргийг хүлээнэ: 1/ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг хэрхэн ойлгох, тайлбарлах талаар тодруулга хүргүүлэх үүрэгтэй; 2/ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг удирдах чиглүүлэх, зохион байгуулах.
4	Гомдлыг шийдвэрлэх, барагдуулах	Хэрвээ хэрэглэгч өөрийн эрх, ашиг зөрчигдсөн гэж үзвэл бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгчид шууд хандах эрхтэй бөгөөд тавьсан

		<p>шаардлагыг эс биелүүлбэл хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газарт утсаар дуудлага өгөх, өргдөл гаргах эрхтэй байна.</p> <p>Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах холбооны байгууллага өөрийн орон нутаг дахь нэгжээр дамжуулан хяналт шалгалтыг хийдэг. Хэрвээ хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдсөн бол хэрхэн хууль, хяналтын байгууллагад хандахыг зөвлөдөг.</p> <p>Хэрэглэгчийн санал гомдлын дэвтрийг бараа, ажил, үйлчилгээ үзүүлэгч ААН-д заавал байлгахыг шаарддаг (төв, салбар, хадгаламжийн касс г.м). Санал гомдлын ном нь дугаарлагдсан, үдэгдсэн, гарын үсэгтэй, тамгалагдсан байх ёстой. Хариуцсан ажилтан нь өдөр бүр өдрийн төгсгөлд санал гомдлын дэвтрийн мэдээллийг (хэрвээ гомдол ирсэн тохиолдолд) цуглуулж, дараагийн өдөр нь журамд заагдсаны дагуу шийдвэрлүүлэхээр удирдлагад шилжүүлнэ.</p>
5	Маргаан шийдвэрлэх альтернатив механизм	ОХУ-ын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, тогтоомжийн дагуу аливаа маргаан нь зөвхөн шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэх зохицуулалттай байна.
6	Хуулийн онцлог заалт, хэсэг	Сайн дурын үндсэн дээр хэрэглэгч нар мэргэжлийн холбоо, ТББ нийгэмлэгийг байгуулан өөрийн дүрэм болон хууль, тогтоомжийн дагуу нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нийгмийн хяналтын худалдан авалт, шинжилгээ хийх, чанарыг тогтоох хууль, хяналтын байгууллагад хандах эрхтэй байна. 2025 оноос эхлэн хэрэглэгчид зар сурталчилгааны бус нийтэд зориулсан мэдээллийг хүргэхдээ орос хэл дээр байх тухай шаардлага нэмэгдсэн.

ХАВСРАЛТ 3. МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН ТАЛААР БУСАД УЛСУУДЫН ТУРШЛАГА:

	УЛС	ТУРШЛАГА
1	АНУ	АНУ-ын муж болгонд англи загварт суурилсан өөрийн гэсэн мөнгө хүүлэлтийн эсрэг хууль үйлчилдэг. 20-р зууны сүүл үед тус хууль банкуудын хувьд үйлчлэхгүй байхаар болгов. Харин сүүлийн жилүүдэд олон муж өртөг өндөртэй зээлээс хамгаалах зохицуулалтыг сэргээж байна. Тухайлбал, банк бус санхүүгийн компаниуд цалингийн зээл зэрэг жижиг зээлд ногдуулах хүүг хязгаарлаж эхэлсэн байна.
2	Армен	Хуулиар Төв банкны бодлогын хүүнээс 2 дахин өндөр хүүтэй эсхүл хэт зохисгүй нөхцөлөөр зээл олгохыг мөнгө хүүлэлт гэж үздэг.
3	Бангладеш	Орон нутгийн зээлдэгч болон хөдөө, аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор бичил зээлийн хүүний дээд хязгаарыг жилийн 27 хувиар тогтоожээ.
4	БНХАУ	Хятадад 2019 оны 10-р сард жилд шилжүүлсэн хүү 36%-иас их зээлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох болсон. 2 жилийн дотор 10 гаруй зээлдэгчдэд жилийн 36%-иас илүү хувиар мөнгө зээлдүүлсэн иргэн эсхүл аж ахуйн нэгжийг “хууль бус бизнесийн үйл ажиллагаа” эрхэлж байна хэмээн үзэж хуулийн хариуцлагад татдаг болжээ. Энэхүү шийдвэрийн дагуу, зээлдүүлэгч нь 2 сая юань зээлүүлсэн, эсвэл зээлийн үйл ажиллагаанаас 800,000 юаниас дээш ашиг олсон нь тогтоогдвол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оноох боломжтой. Мөн 50-иас дээш хүнд зээл олгосон, эсвэл зээл нь зээлдэгч болон түүний гэр бүлийн гишүүдийг амиа хорлох, нас барах, эсвэл сэтгэцийн эмгэгт хүргэсэн тохиолдолд зээлдүүлэгчид хариуцлага тооцох боломжтой гэж заасан байна. 2020 онд Хятадын дээд шүүхээс хувийн зээлийн хүүний дээд хязгаарыг бууруулж “мөнгө хүүлэлт”-тэй тэмцэн жижиг, дунд бизнесийг дэмжихээ мэдэгдсэн. “Зээлийн анхдагч хүү” (LPR)-г (сар бүрийн 20-нд зарладаг, 2025/07/11- ний өдрийн байдлаарх LPR: 3%, 5-аас дээш жилийн хугацаатай LPR нь 3.5%.) 4 өөр үржүүлснээс ихгүй буюу 12% байхаар хүүний дээд хязгаарыг тогтоожээ.
5	Итали	Мөнгө хүүлэлтийн эсрэг хуулинд банкуудын дундаж хүү (Tasso Effettivo Globale Medio (TEGM))-нээс 125%-иар өндөр хүүгээр зээл олгохыг хориглодог. Тухайлбал, TEGM = 4% гэж үзвэл зээл олгох боломжтой дээд хүү нь 9% байна.
6	Киргиз	Киргизийн Төв банкнаас хагас жил тутам тогтоох хүүн дээр 15 нэгж хувиас хэтэрсэн хүүтэй зээлийг мөнгө хүүлэлт гэнэ. Тухайлбал, 2025 оны хоёрдугаар хагаст нэрлэсэн хүү 18.04% байгаа тул хүүний зөвшөөрөгдсөн дээд хязгаар жилийн 33.04% болох юм.
7	ОХУ	2017 онд ОХУ иргэний хуульдаа мөнгө хүүлэлтийн эсрэг “Нэг талаас иргэн, нөгөө талаас хэрэглээний зээл олгох мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй хуулийн этгээд хоёрын хооронд байгуулсан зээлийн гэрээний хүү нь адил төсөөтэй хэлцлээс 2 дахин өндөр буюу зээлдэгчдэд дарамт учруулсан (мөнгө хүүлэх хүү) тохиолдолд хүүний түвшинг жишиг хүү хүртэл бууруулах боломжтой” заалт оруулсан. Мөнгө хүүлэх гэдэгт ердийн зээлийн хүүг 2 дахин нэмэгдүүлсэн зээл олгох тохиолдлыг хамааруулахаар тодорхойлж өгчээ. Тус заалтаар иргэдээс эсхүл банк, ломбард, зээлийн хоршоо бус байгууллагын зүгээс иргэдэд зээл олгож байгаа харилцааг зохицуулжээ. Ө.х. мөнгө хүүлэгчид гэдэгт хэрэглээний зээл олгох үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэд болон хуулийн этгээд нарыг

		хамруулсан байна. Зээлдэгч, зээлдүүлэгчийн маргаан шүүх дээр очвол хүүний түвшинг “бусад хэлцэлд ашиглаж байгаа нийтлэг хүүний түвшин” хүртэл бууруулах боломжтой болсон байна.
8	Португал	<p>Португал улсын Иргэний хуулийн² 1146 дугаар зүйлд мөнгө хүүлэлтийг зохицуулсан байдаг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүгийн хэмжээ хуулиар тогтоосон жилийн хүүнээс 3-5 хувиар өндөр хүүтэй зээл олгохыг хязгаарладаг. • Зээлийн гэрээнд зээлийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлөх нөхөн төлбөрийн хэмжээг 7-9 хувиар тогтоохыг хориглодог. • Хэрэв гэрээнд заасан хүүгийн хэмжээ болон нөхөн төлбөрийн дүн дээд хязгаараас давсан бол автоматаар дээд хязгаарт бууруулж тооцогддог байна.
9	Польш	<p>Польш улсын Иргэний хуулийн³ 359 дүгээр зүйлээр хүүгийн дээд хязгаарыг тогтоосон байдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Хүүг зөвхөн хууль, шүүхийн шийдвэр эсвэл эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно. • Хэрэв хүүгийн хэмжээг өөрөөр заагаагүй бол хүүгийн хэмжээ Польшийн Төв банкны лавлагааны хүүг 3.5 хувиар нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. • Мөн гэрээнд заасан хүүгийн хэмжээ болон нөхөн төлбөрийн дүн дээд хязгаараас давсан бол дээд хязгаар хүртэл бууруулж тооцох зохицуулалттай байна. <p>Өмнөх жилүүдэд жишиг хүүнээс 4 дахин илүү байхыг хориглодог байсан бол 2023 оноос жишиг хүүнээс 2 дахин өндөр хүүтэй зээл олгохыг хязгаарласан байна. Энэ нь өндөр хүүтэй зээл олгохыг илүү хязгаарлалт тогтоох зорилготой байна.</p>
10	Франц	<p>Хуулиар хүүний түвшин хууль ёсны болон тохиролцооны гэсэн 2 төрөлтэй байна. Хууль ёсны хүүг хууль тогтоомжоор тодорхойлно. Харин тохиролцооны хүүгээр хийх гэрээ хэлцлийг заавал бичгээр үйлдэх бөгөөд эс бөгөөс хүчин төгөлдөр бус гэж үзнэ. Ингэснээр эрх зүйн этгээдүүдийн хүүг тохиролцоо эрх чөлөөг хуулиар тогтоосон “мөнгө хүүлэх хүү”-ний түвшнээр хязгаарласан байна.</p> <p>Франц улсын хэрэглэгчийн тухай хуулийн⁴ 314-6 дугаар зүйлд мөнгө хүүлсэн зээл гэдэгт өмнөх улирлуудад зээлийн байгууллагуудаас тухайн төрлийн ижил эрсдэлтэй зээлд оногдуулсан хамгийн өндөр хүүн дээр 1/3-ээс илүү хувь хэмжээгээр нэмэгдүүлэн тооцсон хүүтэй зээлийг ойлгохоор зохицуулсан байна.</p> <p>Зарим төрлийн зээлийн дээд хязгаарыг харуулбал:</p> <p>Ипотекийн зээл: Ипотекийн зээлний⁵ хувьд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэ хүүгийн дээд хязгаарыг дагаж мөрдөхөөр тогтоосон байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ 10 жилээс доош тогтмол хүүтэй зээл: 4.51%; ✓ 10-20 жилийн хооронд тогтмол хүүтэй зээл: 5.45%; ✓ 20 жил ба түүнээс дээш тогтмол хүүтэй зээл: 5.31%;

² <https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/3545>

³ https://przepisy.gofin.pl/przepisy%2C4%2C29%2C191%2C204%2C286910%2C20231016%2Custawa-z-dnia-23041964-r-kodeks-cywilny1.html?utm_source=

⁴ https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006069565/LEGISCTA00003222347/?utm_source=

⁵ https://www.economie.gouv.fr/particuliers/emprunter-et-sassurer/pret-ce-quil-faut-savoir-sur-le-taux-dusure?utm_source=

		<p>✓ Хувьсах хүүтэй зээл: 5.64%;</p> <p>✓ Завсрын зээл: 6.39%;</p> <p>Эргэн төлөлт нь 2 жилээс цаас хийгдэх хөвөгч хүүтэй зээл: 9,24%,</p> <p>Тогтмол хүүтэй зээл: 8,15%;</p> <p>Мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс зээл авч байгаа хуулийн этгээд, хувь хүн: 14,17%.</p> <p>Хүүний дээд хязгаарыг эрх бүхий байгууллагаас Үндэсний зээлийн зөвлөлтэй зөвшилцөн тогтооно.</p>
11	Энэтхэг	<ol style="list-style-type: none"> 1. Махараштра мужийн Мөнгөн зээлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт Мужийн Засгийн газарт баталгаатай зээл болон баталгаагүй зээлийн хувьд мөнгө зээлдүүлэгчдийн авах боломжтой дээд хүүгийн түвшинг тогтоох бүрэн эрхийг олгосон байна. 2. Тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 болон 31.3 дахь хэсэгт Мөнгө зээлдэгчийг Мужийн Засгийн газраас тогтоосон хүүнээс илүү хүү авахыг хязгаарлаж, нийт хүүгийн төлбөр үндсэн зээлийн хэмжээнээс их байхыг тус тус хориглосон. 3. Дээрх хязгаарлалтуудыг зөрчсөн ямар ч гэрээ хүчин төгөлдөр бус байна. 4. Хэрэв 31 дүгээр зүйлийг зөрчсөн бол анхны зөрчилд 25,000 рупи хүртэл, хоёр болон түүнээс дээш удаагийн зөрчилд 50,000 рупи хүртэл торгууль төлөх зохицуулалттай.